



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [f facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)
- <http://rtcc.mrtd.gov.mn>
- info@rtcc.mrtd.gov.mn
- +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2022 оны 2 дугаар сарын дугаар





“Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох, санал дүгнэлт гаргах, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх ажлыг хэрэгжүүлж байна

Гэрчилгээжүүлэлттэй холбоотойгоор тайлант хугацаанд төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх хүсэлтийг 31 аж ахуй нэгж, байгууллага ирүүлсэн.

| Хүсэлт ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн хүсэлт дараах байдлаар шийдвэрлэгдсэн байна. | |
|---|----|
| Баримт бичгийн бүрдэл дутуу шалтгаанаар буцаагдсан | 7 |
| Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж буцаасан | 3 |
| -Ажлын хэсгийн хурлаар дэмжигдсэн | 14 |
| Ажлын хэсгийн хурлаар ороход бэлэн болсон | 0 |
| Хүсэлт ирүүлсэн, одоогоор хянагдаагүй байгаа | 7 |
| Гэрчилгээ олгогдсон | 0 |

Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2022 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А 22 дугаар тушаалын дагуу 12 аж ахуй нэгжийн 117 ширхэг гэрчилгээг хэвлэн Төвийн захирлаар баталгаажуулан авч аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн. Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлж хөтлөн, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.8-д заасны дагуу гэрчилгээ олгосон хуулийн этгээдүүдийн мэдээллийг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдөр тайлагнасан.





“Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, ЗТХЯ-ыг мэдээллээр хангах” ажлын хүрээнд:



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/154 дүгээр тушаалын 13 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”-ыг

үндэслэн 2022.02.22-ны 64 тоотор “Илинк Жэй Ви ложистик” ХХК -ийн 200 тавцант вагонд, 65 тоотор “Монголиантранс лордс” ХХК-ийн худалдаж авч буй 300 хагас вагонд, 02.24-ний 68 тоотор “Баясон ложистик” ХХК-ийн 100 тавцант вагонд шинээр дугаар олгож, 02.09-ний 40 тоотор “Талын хишиг транс” ХХК-ийн түрээсийн 50 тавцант вагоныг, 02.10-ны 41 тоотор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн худалдаж авсан 30 хагас вагоныг, 02.22-ний 66 тоотор “Эвт Аян” ХХК-ийн 1855 чингэлгийг төвийн мэдээллийн нэгдсэн санд, “Өмчлөгчийн код олгох тухай” 2022.02.22-ны өдрийн А/12 тушаалаар “Илинк Жэй Ви ложистик” ХХК-д “17”, 02.23-ний өдрийн А/15 тушаалаар “Шууд хур” ХХК-д “18”, А/16 тушаалаар “Монцемент билдинг материалс” ХХК-д “19”, 02.25-ны өдрийн А/17 “Моншике” ХХК “21” кодыг олгож төвийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.



Нийлүүлэлтийн сүлжээний RFID хэрэглээ-ачааны чингэлэг, ачааны чингэлгийг автоматаар тодорхойлон таних систем ISO 17363:2007 стандартыг орчуулан боловсруулаж байна



Нийлүүлэлтийн сүлжээний RFID хэрэглээ-ачааны чингэлэг, Ачааны чингэлгийг автоматаар тодорхойлон таних систем ISO 17363:2007 стандартыг Төмөр зам, далай ашиглалт, усан тээврийн стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэхээр 2022.01.27-ны өдрийн 30 тоотор Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Зүйлсийн интернет, их өгөгдөл, хиймэл оюун ухаан зэрэг орчин үеийн тренд технологүүдын талаар ойлголт, мэдээллийн аюулгүй байдал, түүнийг хэрхэн хангах, хортой код, компьютерийн вируснуудыг зорилго үйл ажиллагаагаар нь тайлбарласан презентэйшн сургалтын материалыг бэлтгэн Эйбл системийн файлын сан цэсний сургалт, мэдээлэл, олон нийт цэсэнд байршуулж ажилтнууд өөрсдийн чөлөөт цагаараа үзэх суралцах боломжтой болсон.






"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Хоног, сарын мэдээг төмөр замын байгууллагуудас цахим хэлбэрээр тогтмол хүлээн авч мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/92 дугаар тушалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн 2022 оны 1 дугаар сар, Төмөр замын статистикийн үндсэн үзүүлэлтийн мэдээг боловсруулж ЗТХЯ хүргүүлсэн.




ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв




2022 оны 1 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч, ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа зэргээр дүн шинжилгээ хийж, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ. Ачаа тээврийн статистик мэдээг Чингэлэг тээвэрлэлт, тээвэрлэсэн ачаа, ачаа илгээлт, зогчигч тээврлэлтээр сар бүр гарган ЗТХЯ-ны сайдын шуурхай хуралд тогтмол танилцуулан ажиллаж байна.

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




2022 оны нэгдүгээр сард 1979.2 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Ачилт - ачааны төрлөөр
/2022 оны 01 дүгээр сард/



Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



2022 оны нэгдүгээр сард 292.7 мян.тн ачаа дамжин өнгөрсөн байна.


Ачилтаар 2022 оны нэгдүгээр сард нүүрс, хар төмөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1.17 мян.тн ачсан байна.



2022 оны 01 дүгээр сард 1979.2 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 25.2%-аар буурсан үзүүлэлттэй байна.



ИНФОГРАФИК



Суурь бүтэц эзэмшигчээр /тээвэрлэсэн ачаа/

/өссөн дүнгээр/

| Төрийн хүдэр | Төрийн хүдэр | Бүх төрлийн ачаа |
|--------------|---------------|------------------|
| 0.0 мян.тн | 1979.2 мян.тн | 20.70 мян.тн |

Тээвэрлэсэн ачааны мэдээ

/мян.тн/ /өссөн дүнгээр/

Экспорт 2021: 916.8, 2022: 337.5

Импорт 2021: 299.0, 2022: 286.8

Дамжин өнгөрөх 2021: 356.1, 2022: 292.8

Орон нутаг 2021: 1989.7, 2022: 1399.6

2022 /01 сар/ - 1979.2 мян.тн

| | | |
|-------|--------------|------------------|
| Нүүрс | Төрийн хүдэр | Бусад төрөл ачаа |
| 83.2% | 2.8% | 2.4% |

Галт тэрэгний зурмагийн биелэлт

/өссөн дүнгээр/

| Суудал г/т | 2021 | 2022 | Өнгөрүүлэлт | 2021 | 2022 | Ачааны г/т |
|------------|------|------|-------------|------|------|------------|
| | 0 | 443 | Өнгөрүүлэлт | 4317 | 3731 | |
| | 0 | 449 | Явуулалт | 5326 | 3731 | |

Зорчигчийн галт тэрэг явуулалтаар 451 г/т төлөвлөснөөс 449г/т явуулж биелэлт 99,6%, өнгөрүүлэлтээр 451 г/т төлөвлөснөөс 443 г/т өнгөрүүлж биелэлт 98,2%, ачааны галт тэрэг явуулалтаар 3738 г/т төлөвлөснөөс 3731 г/т явуулж биелэлт 99,8%, өнгөрүүлэлтээр 3738 г/т төлөвлөснөөс 3731 г/т өнгөрүүлж биелэлт 99,8% болсон байна.





**Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс**

